

## МОНГОЛ ХЭЛНИЙ ДАВТАХ ЁСНЫ СУДЛАЛЫН АСУУДАЛД

Jia Qi, ӨМБИС

## Abstract

Reduplication in linguistics is a morphological process in which the root or stem of a word (or part of it) or even the whole word is repeated exactly or with a slight change in any languages. For instance, as defined in the linguistic dictionaries, reduplication is used in inflections to convey a grammatical function, such as plurality, intensification, etc., and in lexical derivation to create new words. It is often used when a speaker adopts a tone more “expressive” or figurative than ordinary speech and is also often, but not exclusively, iconic in meaning. Reduplication is found in a wide range of languages and language groups, though its level of linguistic productivity varies. Otherwise, it is purposely repeated in world languages.

Reduplication is often described phonologically in one of two different ways: either (1) as reduplicated *segments* (sequences of consonants/vowels) or (2) as reduplicated *prosodic units* (syllables or moras). Many languages often use both full and partial reduplication, as in the *momordi* example: the first syllable ‘*mord*’ is reduplicated and formed the word ‘*momord*’ as an example of partial reduplication.

As observed the function of reduplication in world languages, the most common function was to express polysemy, and to intensify and repeat the general meanings. However, in some languages, reduplication is often described morphologically as a reduplication of linguistic constituents (i.e. words, stems, roots). It basically functions as forms of verb tenses, case inflections and as forming the verbs of nouns. In this case, the *base* is the word (or part of the word) that is to be copied, but it expresses meaning of the verb tense.

In Mongolian language, there are the distinctive forms, structures, models and languages of reduplication. For instance, reduplication of the base, root, word, and phrase has been explained and defined by different terms such as reduplication, repeated word, reduplication rule, alliterating words, and mimic alliterating words and etc. This paper intends to discuss the different forms, characteristics and rules of reduplication in Mongolian language. The term ‘reduplication’ has broad concepts: the reduplication of root or stem of a word, and duplicating words, phrases, clauses, sentences and texts as well.

## Түлхүүр үг

Давталт, давтмал үг, давхац үг, давтан хоршоо, цуурай үг, давтах ёс, бүрэн бус давталт

## Удиртгал

Дэлхийн олон хэлний давталтын үүргийг ажиглавал олны утга заах, хүч нэмэгдүүлэх, давтах утга заах үүргээрээ төстэй байна. Гэтэл зарим хэлэнд давталтыг үйл үгийн цаг, үйлээс нэр үг үүсгэх, тийн ялгалын хувиргалын үүргээр хэрэглэх зэрэг тохиолдол байдаг байна. давтал хаясан гэх тухайн үгийн өнгөрсөн цагийн утгыг заадаг байна (Бат-Ирээдүй, 2013, х-3).

Монгол хэл бол давталтын хэлбэр, бүтэц, загвараар баялаг бөгөөд үндэс давтахаас эхлээд, үг давтах, хэллэг давтах, өгүүлбэр давтах, эх давтах хүртэлх өргөн ухагдахууныг энэхүү өгүүлэлдээ авч хэрэглэсэн болно.

Монгол хэлнээ хамгийн өргөн давтамжтай нь үг давталт бөгөөд энэ талаар эрдэмтэд голлон судалж иржээ. Монгол хэлний хувьд үг давталт нь маш түгээмэл үзэгдэл юм. Үг давтсанаар ямар ямар утга илэрхийлэх талаар эрдэмтэд дор бүрнээ тайлбарлаж, хэлзүйн болон үгийн сан утгын талаас нарийн судалгаа хийж иржээ.

Эрдэмтэн П.Бямбасан, “Үг давтахын нэгэн учир” бүтээлдээ, “Давтагдаж байгаа үйл үг хэлзүйн хэлбэрээрээ ижил ба ижил бус хоёр янз байдаг бол давтагдаж байгаа нэр үгийн хэлзүйн хэлбэр бас ижил ба өөр байхаас гадна үндсэн үгийн авианы бүтцийг хэвээр нь давтах, гутал мутал, дэвтэр мэвтэр, мах зах гэх мэтээр хоёр дахь үгийн авианы бүтцийг өөрчлөн давтах хоёр янз байна. Ижил давтагдаж байгаа нь нэр үгийн хоёр дахийг харьяалах, өгөх орших, гарах, заах, хамтрах, чиглэхийн тийн ялгалаар хувиргаж өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн, тусагдахуун зэрэг гишүүний үүрэг гүйцэтгэж байгаа холбогдох үгэнд нь захируулж болох ба хамаатуулах нөхцөлөөр өөр үгтэй холбодог” (Бямбасан. П. 1978, х- 87-97) гэж давтмал үгийн үндсэн шинж чанарыг тодорхойлжээ.

Монгол хэлний давталтын бас нэг утга бол олны буюу олон тооны утга илэрхийлэл байдаг.

Давтах ёсны хэлзүйн байгууллын талаар

профессор Ц.Өнөрбаян судалгаа хийж орчин цагийн монгол хэлний давталтыг бүрэн давталт, бүрэн бус давталт гэж хоёр хуваажээ. Үүнд, монгол хэлний жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэр, орон цагийн нэр, төлөөний үг, үйл үг, чимэх үгийг давтаж болно гэдгийг утга зохиолын жишээ баримтаар баталж, ялангуяа үйл үгийн давталтын хэлзүйн хэлбэрийн тогтолцоог гаргажээ. Ингэж тогтолцоог нарийн задлан судалснаар давталтын утга илэрхийлэх үүрэг буюу голдуу давтамж утга илэрхийлэх боломжийг тоочин гаргажээ. Монгол хэлний давталтыг ажиглавал байгалиасаа давталттай болдог хөдөлгөөн, дуу чимээ зэрэг зүйлийг илэрхийлэхэд хэрэглэдэг нэг ёс байх шиг байна. Жишээлбэл *хүн амьтны дуу авиа, шувууны далавч гэх мэт араатан болоод гэрийн тэжээмэл амьтны явал хөдөлгөөн, байгалийн элдэв үзэгдлийн давтамжит чимээ, үйл*, зэргийг илэрхийлэхдээ тухайн үгийг хоёроос дээш давтах маягаар утгыг үзүүлдэг байна.

Бүрэн бус давталтын талаар профессор Ц.Өнөрбаян “...бүрэн бус давталт нь үг бүтээх үүрэг нь давамгайлсан давталт юм. Монгол хэлний баримтыг ажиглавал бүрэн давталтаас бүрэн бус давталтыг дамжин зэрэгцсэн нийлмэл үг үүсдэг зүй тогтолт дараалал байдаг... бүрэн бус давталт нь утгын хувьд задгай хэв шинжтэй байна...” (Өнөрбаян.Ц. 2006, х-12-13) гээд *гөрөөс мөрөөс, эрэн мэрэн, арав марван, цаана маана, өнөөдөр мөнөөдөр, тийм мийм, усалж мусалж* гэх мэт үгийг жишээ болгон авчээ. Давтмал үг түүх цуглуулах явцад бүрэн бус давталтыг ажиглавал, монголын утга зохиолын хэл найруулгад цөөнгүй таарч байна. Жишээлбэл, “Сохор мохроо ч хайрлалгүй соёо шүдээ ч хайрлалгүй үхээрийн муу чонотой л үзэлцэж гэнэ нэгийгээ” (*Ш.Гаадамба, “Сохор нохой”*), “Жанжин манжин нь санд мэнд босон гүйлдэв.” *Д.Нацагдорж*, “Бүр харь элгийн хүнтэй үерхэж нөхөрлөх гээд байсан юм бол нутаг ус, дүр төрх нь арай эерүү юм орос моросуудтай нөхөрлөхгүй дээ” (*Ц.Буянзаяа, “Шинэ цагийн Молом тойны намтар”*), “Үгүй байх аа, хавар эх нь очсон, үглэж дуулсан, цол мол хамгаалах юм ярьж байна гэсэн” (*Р.Ганбат, ‘Хадлангийн оросууд’*); Ингээд бид монгол хэлэнд байдаг, монголын уран зохиолын жишээ баримтаар батлагдаж байгаа энэхүү бүрэн бус давталтыг “бүрэн хэмжээгээр” хүлээн зөвшөөрч яах аргагүй монгол хэлний давталтын тодорхой нэгэн хэв маяг мөн хэмээн үзэж байна.

Монгол хэлний хувьд давталттай хамгийн их хольж хутгадаг үзэгдэл бол хоршоо үг юм.

Профессор М.Базаррагчаа, “Үг хорших нь давтахыг, үг давтах нь хоршихын утгыг тус тус агуулсан байдаг тул үг давтахыг үг хоршихоос

ялгахад түвэгтэй юм. Гэвч “эрэн мэрэн, үхэр мэхэр, цав цагаан, хав хар, яв явсаар, гэр гэртээ гэх мэтээр язгуурыг бага сага өөрчлөн давтсан нь үгийн санжсан утгыг бус, үйлийн үргэлжлэх, давтах, эрчимжүүлэх, хэсэгчлэх зэрэг хэлзүйн хийсвэр утгыг илтгэж байна. *Бага сага, ач тач, эрэн мяраан, хага хуга, хальт хулт, арай чарай, шалдар булдар, илүү булуу, нүл пал, үүр цүүр, ахих дахих, эрвийх сэрвийх, урвах хөрвөх* гэх зэрэг хоршоо үг нь давталтаар үүссэн юм шиг авч дээрх давталтаас чөлөөтэй бус, тогтвортой байдгаараа ялгаатай юм. Тодруулбал, эрэн мяраан, хага хуга гэх мэтээр авианы сэлгэц болон гийгүүлэгчийн сугарлаар нэг үгээс салаалан үүссэн тул адилавар үгс давтагдсан боловч “Яван явсаар хүн хүн гэр гэртээ орцгоожээ.” гэхчилэнгийн чөлөөт давталтыг бодвол хоршиж буй үг нь хэвшин тогтворжсон байдаг. Үүнээс үзвэл давтах шинж нь хэлзүйн утгыг илтгэх бол хорших шинж нь үгийн сангийн утгыг илтгэж байна” (Базаррагчаа.М. 1990, х- 5-6) гэжээ. Өөрөөр хэлбэл хорших, давтах хоёр бол хоёр өөр утга илэрхийлдэг хоёр өөр зүйл гэсэн санааг эндээс ойлгож болно.

Хоршиц бол давтац биш, давтац бол хоршиц биш юм. Давталт бол үгийн сангийн биш хэлзүйн үзэгдэл гэж үзэж болох бөгөөд шинэ үг бүтээж байгаа биш шинэ утга үүсгэж байгаа гэдгээрээ онцлог юм. Монгол хэлний давталтаар хэлзүйн өөр өөр утга үүсэж байдаг нь утга зохиолын жишээ баримтаас үзвэл илэрхий байна. Б.Пүрэв-Очир “Хуучин сүмийн дээвэр доор шувуу шувуундаа жиргэн, хошуу хошуугаа нийлүүлэн шувуу шувуундаа дуулна (*Б.Лхагвасүрэн*) гэдэг өгүүлбэрт шувуу шувуундаа, хошуу хошуугаа, гэсэн давталт давтагдаж байна. Иймэрхүү давталт нь аливаа гадаад хэл рүү орчуулахад илүү анзаарагдаж утга нь ялгарч мэдэгдэж байдаг. Гадаад хэлний орчуулгыг давтамал үгийн утгыг ялгаруулах бас нэгэн шалгуур болгож болох талтай (Бат-Ирээдүй, 2013, х-8-9).

Профессор Б.Пүрэв-Очир, “Монгол хэлэн дэх давталтын онцлог, хэв шинж, утга, үүргийг ажиглахад авиан зүйн учир холбогдлоос үгзүйн учир холбогдолтой болж, улмаар үгийн сан-өгүүлбэрзүйн учир холбогдолтой болох тийм хандлага, тогтолцоо байна” (Баттулга, Ч. 2012, х-71) гэж үзжээ. Бид монгол хэлний давталтыг бүрэн ба бүрэн бус давталт хэмээн ангилах профессор Ц.Өнөрбаяны саналтай бүрэн санаа нийлж байгаа бөгөөд харин бүрэн бус давталтад хамруулсан нэгэн зүйл давталттай санал нийлэхгүй байгааг энд дэлгэрэнгүй тайлбарлана.

Мөн давталтын ерөнхий шинжийг ажиглаж давталтын илэрхийлж байгаа утгын

талаар тодорхой тогтолцоо бүхий зарим ажиглалт хийснээ толилуулж байна. Монгол хэлний давтмал үгийн хувьд “Давтсан үг нь заавал язгуур юм уу үндэс нэгтэй байх учиртай. Хэлзүйн учир шалтгаанаар төрөл бүрийн дагавар нөхцөл залгаж болох боловч заавал үндсэн үгийг давтсан байх учиртай”.

*Тийм учраас монгол хэлний “эл хуль, дэл сул, мурий сарий, бүдэг бадаг, хар хур, хам хум, гэх мэт эхний үгэнд оролцсон гийгүүлэгч юм уу эгшиг дангаараа юм уу давхраараа өөрчлөгдөж байгааг нь хоршоо үгэнд, харин үндсэн үгийн эхний үсэг дээр нэмэгдэх юм уу тухайн үгийг бүтцийн хувьд өөрчлөхгүйгээр бүтэн болон хагас давтаж байгаа үгсийг давтмал үг хэмээн тооцож болмоор санагдана. Тухайлбал, “ач тач, ой той, бүүр түүр, цүүр, гангар гунгар, бага сага, чив чив, тог тог, хонь монь, морь зорь, нот зот, идэх мэдэх, харах марах” гэх үгс нь давтмал үг болно гэж үзэж буй юм.*

Ийм учраас энэхүү давтсан үгийн толь бичигт ч иймэрхүү жишээ оруулсангүй. Үүнийг бас профессор. Б.Пүрэв-Очир “Монгол хэлэнд цав цагаан, цэв цэнхэр, хөв хөх, ув улаан, нов ногоон, ив ижил, ав адил, зав залуу гм-ээр гол төлөв тэмдэг үгийн язгуурыг эс өөрчлөн давтаж тухайн тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлдэг ёс арвин бий. Энд ца, цэ, хө, но, за гм язгуурыг өөрчлөн давтаагүй зөвхөн язгуурын авианы бүрхүүлд -в авиа жийрэглэж, авиан зүйн аргаар давтсан онцлогтой. Эрдэмтэн П.Бямбасан бээр, “Бид нэг үгийг давтан хэрэглэхийг хэлзүйн утга илрүүлэх арга, давтагдаж байгаа нэг үгийг энх тайван, эрдэм мэдлэг, суртал нэвтрүүлэг, ах дүү, халуун хүйтэн гэх мэт хоршсон нийлмэл үгтэй адил зүйл биш, товчхон хэлбэл хоршсон нийлмэл үг биш гэж бодож байна.” хэмээн үзжээ.

Судалгаа шинжилгээний зүйл, хэлний материалаас үзвэл давталт нь хоёр гишүүнтэй байх бөгөөд тэр хоёр гишүүн нь яг адил нэг хэлбэрээр давтагдах, хоёр гишүүний аль нэг нэр, үйлийн ямар нэгэн нөхцөл авч хэлзүйн хувирлаар хувиран давтагдах, нэгний нь эхний авиаг м, з зэрэг авиагаар сольж давтах, давтах үг нь эгшгээр эхэлсэн бол м, з зэрэг гийгүүлэгч нэмж давтах хэдэн янзын хэлбэртэй байна” (Бат-Ирээдүй. Ж. 2013, х-11) хэмээн тодорхойлсон байна.

Ингэж үзвэл давталт нь хэлний зүйн асуудал болж түүний арга хэлбэрээр утгыг үзүүлдэг үзэгдэл болох нь тодорхой байна. Бидний хувьд цуглуулсан хэлний хэрэглэгдэхүүнийг ажиглан үзвэл монгол хэлний давтмал үгийг бүтцийн хувьд дараах мэт байж болох юм хэмээн үзэж байна.

Үүнд: үг + үг (ангас ангас, байн байн, барь барь, бичиг бичиг, биш биш, дассаар дассаар,

дош дош, дуудаад дуудаад, ерөөл ерөөлийн, ёдор ёдор, жигүүртэн жигүүртэн, имрэн имрэн, манан манан манан, майл майлсаар, наадан наадан, очиж очиж, гэх мэт), *холбоо үг + холбоо үг* (амаа ангайгаад, амаа ангайгаад; даргиатай болоод, даргиатай болоод, дуниарч тодроод л, дуниарч тодроод л, жаргалан будан, жаргалан будан, жижигхэн түүний, жижигхэн түүний, жижигхэн цагаан, жижигхэн цагаан, цахилан цогин, цахилан цогин гэх мэт), *хэллэг + хэллэг* (бага л харын, бага л харын, журай гэлдэн журай найгас найгас, натс натс, гэх мэт.)

Монгол хэлний жишээ баримт, найруулгын ур маягийг нягтлан үзвээс давтмал үгийн илэрхийлж байгаа хэлзүйн утгыг доорх мэт ангилж болмоор санагдана. Тухайлбал, Үйл хөдлөл зөвхөн давтах буюу дахин давтан болохыг заах утга илэрхийлэх: *ангас ангас, тонгос тонгос, нуг нуг, атис атис* гэх мэт.

Хүн ба юм, үзэгдлийн олны буюу төрлийн олон тооны утга илэрхийлэх: *айл айл, хун хун, тал тал* гэх мэт. Үүнийг П.Бямбасан, “Нэр үгийг ижил ба ижил бус хэлбэрээр давтаж, давтагдан байгаа нэр үгээр нэрлэгдсэн зүйл ганц бус болохыг үзүүлдэг байна”, проф. Б.Пүрэв-Очир “...үгийн хэлбэр давтсан, үгзүйн үндэстэй, хэлзүйн арга болдог давталт” хэмээн нэрлэжээ.

Үгүйсгэх хэлц утга илэрхийлэх: *явж явж, очиж очиж, байж байж, тэгж тэгж* гэх мэт.

*Ялгах утга илэрхийлэх*: шувуу шувуундаа, хун хундээ, нохой нохойдоо гэх мэт.

Дахин давтан болох дүр байдлын утга илэрхийлэх: *бувар бувар, бөг бөг, тас тас* гэх мэт.

*Давуу зэрэг илэрхийлэх*: сайхнаас сайхан, ариухнаас ариухан гэх мэт.

*Дуу чимээ илэрхийлэх*: тас тас, шал шал, шол шол, шуг шуг, дунгэр дунгэр, хон хон, хав хав, хогир хогир гэх мэт.

Цаг хугацааны утга буюу үйл хөдлөл нь харьцангуй удаан хугацаанд үргэлжлэн болсон утга илэрхийлэх: *явж явж, алхаж алхаж, гуйж гуйж*, (Бат-Ирээдүй. Ж. 2013, х-14-15)

Монгол хэлний давтмал үгийн бас нэг онцлог бол ижил хэлбэртэй, өөр утгатай байж болдог бөгөөд давтмал үгийн ижил үг гэж бий гэсэн үг.

Давталтын тухай ярихад Монгол яруу найраг, уран зохиолын төрөл бүрийн хэлбэрт хэлзүй, найруулга зүйн үүрэг учир шалтгаанаар хэлний төрөл бүрийн давталт бий болсоор байна. Энэхүү найруулгын давталтын ур маягууд бол сэтгэлгээний царааг илэрхийлэх, уран зохиолын боломжийг харуулах бас нэгэн сонин баримт яах аргагүй мөн гэж бодогдоно. Энэхүү найруулгын үүргээр үүсэн бий болж байгаа давталт бол

хэлзүйн давталтаас бүтэц, үүргээрээ нэлээд өөр бөгөөд гагцхүү зохиолыг уран яруу болгох, хүмүүний ой тойнд ойлгуулах, утга яруу цогцолыг олох, сондгойруулахгүй байх зэрэг олон зүйлд учир холбогдолтой хэв маяг болж байна.

Монгол хэлний давталтын онцлог юу вэ? Монгол хэлэнд үг давтахдаа ихэнхдээ хосоор буюу хоёроор давтдаг боловч цаашлаад гурав, дөрөв, тав хүртэл “үсэрч” дараалан давтах тохиолдол байгааг проф. Б.Пүрэв-Очир мөн ажигласан байна. Жишээ нь, “Юу ч биш, юу ч биш, юу ч бишийн дотор юм юм бий” (*До. Цэнджав*), гэхэд гурав гурваар, “Далай далай гэвч далай далайдаа цутгадаггүй юм аа, дарс дарс гэвч, дарс дарсныхаа аманд уусдаггүй юм аа” (*До. Цэнджав, “Миний бодол”*) гэхэд дөрөв дөрвөөр угсарсан бол, “Найгаад найгаад найгаад найгаад найгаад ганхахуйд насны жаалхан хонгор хүүгээ наадам болгонд санаад байна хө” гэхэд тав утсарч давтсан байх жишээтэй.

Монгол хэлний давталт өөр нэг сонин зүйл бол нэг өүүлбэрт хоёроос дээш, хоорондоо ялгаатай өөр өөр хэдэн ч давталт орж болдог нэг боломж бас байдаг байна. Жишээлбэл, Яндан хогир хогир хөдлөн, өрх сэв сэв хийн гэрийн гадаа элдэв юм савс савс хөдөлж эхлэв бололтой. Асар удсангүй яндан бүр чахар чахар савчиж, өрх ургаш хойш савж хаяагаар салхи хүүдийлэж хуугиж эхлэв” (*Б.Бааст, “Ногтруу”*), Нүүдэл нүүдэл үүлэнд нь саран тормолзож эрхэлнэ, нүгэл нүглийг мартан, нүд нүдэндээ эрхэлнэ” (*БЛхагвасурэн, Эрхлэхийн заяатай хорвоо*”).

Монголын уран зохиолын бүх төрөл түүний дундаас хүүхдийн уран зохиолын найруулгад давтмал үгийг маш их хэмжээгээр хэрэглэдэг нь ажиглагдаж байна. Тухайлбал, бид хүүхдийн уран зохиолын хамгийн түгээмэл сэдэв болох туулайн тухайн шүлгүүдэд түүний хөдөлгөөн, үйл, дүр төрх, байдлыг илэрхийлэх давтмал үгийн хэрэглээ их байна.

Учир нь ийнхүү давтаж хэлсэн зүйл бол хүний ялангуяа хүүхдийн оюун ухаанд амархан тогтох бөгөөд тухайн зүйлийн дүр дүрслэлийг тогтоох, хялбар хурдан таньж мэдэж ойлгоход чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Жишээлбэл, монгол оньсогонд оролцсон үгийн бүрэлдэхүүнийг ажиглавал хүмүүсийн сайн мэдэх, *өдөр тутмын* дөөдэй дөөдэй, дуудий дуудий, жаргай жаргай, жийл жийл, *жөвөн жөвөн, лар лар, маахар маахар, мидар мидар, мэгэр мэгэр, мээг мээг, наг наг, ноог ноог*, олон давтмал үг хэллэг байх бөгөөд эдгээрийн ихэнхи нь тайлбар толь бичигт байдаггүй учраас утгыг тайлж мэдэхэд зарим бэрхшээл гардаг байна.

## Дүгнэлт

Бид эрдэмтдийн судалгаан дээр үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

“Давталт бол үгзүйн үзэгдэл бөгөөд үгзүйн төрөл бүрийн хэсгийг үгийн сан, хэлзүйн янз бүрийн үүргээр давтдаг байна.

Давталт нь дэлхийн олон хэлэнд байдаг нийтлэг үзэгдэл бөгөөд төрөл бүрийн учир зорилгоор давтдаг байна.

Аливаа хэлбэрийг хэсэгчлэн болон бүхлээр давтах нь үгзүйн процесс юм.

Дэлхийн олон хэлний давталтын үүргийг ажиглавал олны утга заах, хүч нэмэгдүүлэх, давтах утга заах үүргээрээ төстэй байна. Гэтэл зарим хэлэнд давталтыг үйл үгийн цаг, үйлээс нэр үг үүсгэх, тийн ялгалын хувиргалын үүргээр хэрэглэх зэрэг тохиолдол байдаг байна. Давтвал хаясан гэх тухайн үгийн өнгөрсөн цагийн утгыг заадаг байна.

Монгол хэлний давтмал үг бол бусад гадаад хэлний нэгэн адил бүрэн ба бүрэн бус гэсэн хэлбэртэй, голлон хэлний зүйн утга илэрхийлэх үүрэг гүйцэтгэх, уран зохиолын төрөл бүрийн найруулга тэр дундаа аман зохиол, хүүхдийн зохиолын найруулгад өргөн дэлгэр хэрэглэгддэг хоршоо үгээс ялгаатай байна.

## Ашигласан материал

- П.Бимбасан, 1979 “Үг давтахын нэгэн учир” Хэл зохиол судлал, 13-р боть, 9-р дэвтэр. Улаанбаатар.
- М.Базаррагчаа, 1990, “Монгол хэлний хоршоо үгийг хэрэглэх тухайд”. Улаанбаатар.
- Ч.Баттулга, 2012, “Монгол хэлний хоршоо үгийг үүсэл гарлын асуудалд”. Монгол судлалын чуулган, №12(47). Улаанбаатар
- Ж.Бат-Ирээдүй, 2011, “Монгол хэлний хоршоо, давтмал үг хэллэгийн сан”. Улаанбаатар
- Б.Пүрэв-Очир, 1998, “Монгол хэлэн дэх зарим давталтын онцлог, утга, найруулгын үүрэг”, Монгол хэлний өгүүлбэрзүй - 2, Улаанбаатар
- Ц.Өнөрбаян, 2006, “Орчин цагийн монгол хэлний давталтын арга, түүний үүрэг”, [Монгол судлалын чуулган, Боть 6. 12-22 дах тал. Улаанбаатар.
- Т.Пагва, 1976, “Хэлшинжлэлийн удиртгал. Улаанбаатар